

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дамдин	Дугаар	L194
Оршин суугаа аймаг	Ховд	Оршин суугаа сум	Жаргалант сум
Төрсөн газар	Жаргалант сум	Төрсөн он	1922
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Манханы Зэргийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ХОМН 107
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сар	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх

Ховд аймгийн Манхан сумын Зэргийн хийд

Дамдин: За юу ярих уу?

Билэг-Өрнөх: Одоо өөрийнхөө л бодож явдаг юмаа, Зэргийн хүрээнд сууж байсан тухайгаа, хаана байрладаг, хэдэн ламтай байсан ?

Дамдин: Манхан чиг хоёр хүрээтэй л байсан. би бол Зэргийн хүрээнд банди ухаантай. Жалцав, Шийрэв гэдэг хоёр ламын шавь болж, Мөнхнасны Тогмид гэж бид хоёр л тэр хоёр ламын хоёр шавь болж анх хүрээн дээр очсон юм. Тэгээд л бага гэлэн нь Жалцав гэдэг гэлэн бид хоёрт төвд хэлэн дээр Төвд ном заадаг байлаа л даа. Тэгээд яахав тэр цээжлэх л маягтай байсан болохоос учирт утгыг нь ч ойлгож байсангүй. Тэгээд л өнөөхийг нь ухаан нь хулсан үзэг бариад л тийм тийм гээд л дууриагаад л хэлдэг, дууриагаад л уншдаг тийм л байла. Ямар ч ойлголтгүй, юугийг нь мэддэггүй. Уг нь жоохон ес, аравтай л байсан байх. Тэгээд Тогмид бид хоёрыг чинь их магтдаг байлаа, манай гэлэн бусад лам нар. Манай том гэлэн бол голцуу эм барьдаг. Одоогоор хэлвэл эмч маягийн хүн байсан юм уу, дандаа хүн ирж эм залдаг. Бага гэлэн бол бид хоёрт ном заадаг. Иймэрхүү л нэг 2, 3 жил байлаа. Харин зуны цагт эмийн ургамал түүдэг, энийг түү гээд л заагаад гэх юм уу бид хоёрыг хөдөө гаргачихна. Бид хоёрын хоёулаа байсан наөхцөлд бол одоогийн энэ банди нар шиг тэр сүм дуганд орж хурж тэдэнтэй хамт тэгж байсангүй, дандаа гэрээрээ. Гэхдээ лам нар бол бишгүй л нааш, цаашаа явдаг. Хурал хурдаг, хурал хурж байна гээд л эгнэж суучихаад тэр Зэргийн хүрээ чинь Манханд л томд тооцогдож байсан хүрээ. Бараг 4 янзын, 6 янзын ч гэлүү сүмтэй. Одоо дацанд ч гэдэг, жүдийнх юу юуных ч гэлээ хурлын... Одоо мэдэхгүй байна аа, заримыг нь ч одоо. Тэгээд л яахав дээ нэг хоёр банди, том гэлэн маань голцуу ийш тийшээ залагдаж. Нөгөө эмч маягийн хүн учраас тэгдэг юм байлгүй дээ. Голцуу л одоо явчихдаг, хааяа гэрт байхаараа дандаа олон тунгаас эм боож улсуудад өгдөг тийм эмч л байсан, ерөөсөө тэр.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Билэг-Өрнөх: Ямар шашны зан үйл хийдэг байсан бэ, танайх сор залдаг, цам гардаг? Тиймэрхүү зан үйл хэдийд хийдэг байсан юм?

Дамдин: Өө цагаан сарын 15 болохлээр чинь майдар эргэдэг. Тэр болвол их нутгийн бүх хүн цугладаг. Морьтой, малтай лам нар ч одоо хүн хөлд дарагддаг. Тэгээд тэр майдрыг чинь одоо нэг жороо морин дээр, одоо эмээл гэдэг юм уу даа, нэг тийм эмээлэн дээр суулгаад яачихсан л байдаг юм байлгүй дээ, бодвол.Тэгээд хүрээ эргэж өнөө жороо морьтой тэгж явна. Тэгээд ардууд хойноос нь , тэр чинь одоо дандаа наминчилсан, шүтэж биширсэн тийм л улсууд. Тэгээд л нэг баахан хөл болж байгаад л тарцгаадаг, майдрын 15 гэдэг нь. Тэрний дараа чухам хэдийд нь бас нэг би сайн юугийг нь мэдэхгүй, цам гэж гоё юм болно.Нэг ёсны тэр янз янзын одоо энэ гадаадын музей энэ тэрт байна ш дээ, их нарийн нягт хийсэн багнууд. Тэр багнуудыг өмсөөд цам харайна. Цам харайдаг тусгай бэлтгэлтэй, сургууль хийдэг бид хоёроос арай томхон тийм банди нар голцуу. Тэр юунд нь, одоо Хашин хаан ч гэдэг билүү дээ, нэг тийм цагаан юу байдаг юм аа. Олон лам л тэнд тоглодог. Бүрээ бишгүүр, одоогийнхоор бол хөгжмийн аянд, хөгжмийн аяар. Тэр цам болоход чинь бас нутгийнхан бараг ойр хавийн улсууд ч ирдэг юм байх.Тэгээд л тэр юугийг чинь үзээд л хоноод л өнжөөд л , тэнд чинь харин хавар одоогоор бодоход чинь ер нь хоёр сар, гурван сарын хавьд байсан юм уу даа, бүх тэр манай Зэрэг гол чинь тэмээ ихтэй байсан газар л даа. Тийм учраас тэр бүх буурнуудыг эзэд нь авчирч хүрээ эргүүлдэг, тэр цамын үед. Тэгээд өнөөдүүлийг чинь тавихлээр оруу нь бараг гарч байгаа үеийн тэгээд ногт могой их гоёсон байдаг юм даа, Оруу буур, угаасаа буур чинь их сүртэй ш дээ. Тэгээд хүрээ эргүүлчихээд ногтыг нь тэр хонхтой,улаан даавуугаар яасан, тийм ногтоор буурыг ногтолсон тэр чинь их сүртэй өмсгөл ч гэмээр юм шиг. Тэгээд тэр ногтыг нь аваад эздүүд нь тавьчихаар буурууд чинь баахан ноцолдож тэгж байгаад л тэгээд нутаг нутаг руугаа хот хот руугаа тийшээ л явцгаадаг. Тэднийг нь л бид их сонирхож, ялангуяа хүүхдүүд банди нар, хүрээ хийд дээр цугласан хүмүүс ч их хардаг.

Билэг-Өрнөх: Лам нар нь хаана амьдардаг байсан юм?

Дамдин: Өө лам нар тэр нэг хүрээнд, одоо хүрээн дотроо гэх үү дээ нэг бөөн хэсэг газар, хурал номоосоо гараад л , тэр дуган сүмээсээ гараад л гэр гэртээ. Зарим нь хашаатай, зарим хашаатай. Ганц нэг байшин, голцуу л одоо харин нэг хоёр жижигхэн байшинтай байдаг байсан Зэргийн хүрээний лам нар чинь. Тэрэндээ юм хумаа хадгалдаг байсан юм байгаа биз дээ, иддэг уудаг юм өвөлд бол.Одоо ч гэсэн бараг байх шиг байна лээ, тэр зарим үлдэгдэл нь.Иймэрхүү л байж байгаад тэгээд юунаас хойш нэлээн сулраад л хасгийн юу гэдэг юм даа одоо, хасгийн дээрэм нэг зун болсон юм аа. Гучин хоёр онд уу, гучин гурван онд уу зуслан дээгүүр явж доошоо нүүж байсан, тэгтэл цаанаас энэ баруун тийшээгээс баахан тийм хасаг орж тэрнээс болж хугацаанаасаа нэг 2, 3 хоногийн өмнө орсон болов уу даа, уулынх чинь зусланд гарчихсан.Ер нь зусланд гардаг юм ш дээ, тэгээд л гол чинь эзгүй болчихно. Тэрнээс хойш чинь тэр чинь тэгээд гучин гурван он юм байх аа. Тэрнээс хойш чинь сулраад л улс амьтан чинь бурхан номоо ил далд ийш тийш нь зөөгөөд л тэр зүүн уул, баруун уулын тэндээс ер нь их зөөсөн дөө, сүүлд нь сургийг нь сонсоход дандаа ууланд, агуй магуйд тавьдаг. Одоо ч гэсэн байна л гэж,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

манайхны эцэг, эхийн шүтдэг садан төрлийн улсууд хүртэл тэр бурхан шөнө аваачиж их газар ухаж, тэнд байрлуулж дээр овоо босгож тэр хөдөлгөөнөөс хойш тэгсэн юм одоо болтол байдаг л гэж байна лээ.

Билэг-Өрнөх: Ямар лам нар тахидаг байсан юм бэ, тэр сүмийн лам нар овоо босгоод тахидаг газар байсан уу?

Дамдин: Байсан, байсан. Наймдаа овоо гэдгийг хавар бүрийд тахидаг байлаа. Нэг булаг байдаг юм аа, тэр миний мэдэж байгаагаар энэ тэнд ухаа гүвээ тэр Зэрэг сүм, Манхны гурвын хооронд Бүүвэй гээд нэг зоо байгаа юм л даа, хар зоо. Тэрнийг бага гүвээ их гүвээ гэж хэлдэг юм, тэр их гүвээн дээр. Бас эхэн дээрээ овоотой, тэр овоог тахиж, хэдийд нь тахиж байсан юм. Тахиж, морь энэ тэр уралдаж тэгдэг тийм юм энд тэнд бишгүй л байлаа л даа.

Билэг-Өрнөх : Сүм хийд яг хэдийд хаагдсан юм бэ?

Дамдин: Гучин зургаан, гучин долоон онд байх аа. Тийм ээ, гучин долоон оны өвөл хаврын хооронд юм уу даа бас л майдар цам болно гэж байсан үеэр машин ирж лам нарыг ачаад баривчилж байсан юм байна. Тэгээд хүн амьтан чинь сүжиг буурсан, тэрнээс чинь хойш юмыг нь битүүмжлээд гэрийг нь цоожлоод лацадсан. Тэгээд зарим лам нар чинь оройхон л юм гэнэ лээ, хоолоо хийгээд яг гаргаж байтал тэгээд машин ирээд тэд нарыг дуудаад л одоо ачдаг юм байлгүй дээ. Тэгээд машин дүүрэн ачаад л тийм л юм болсон гэсэн. Тэгээд тэр нь бүр таван сар, зургаан сар хүрж байж задлав уу яав, тэгээд тэгсэн хоолоо ч идэж амжаагүй гаргаад л тэгээд тэр үлдэгдлийн хальс мальсаар дүүрчихсэн юмнууд л байсан гээд тэгэхэд чинь бараг ил хэлдэггүй. Шивэр , авир гэж хоорондоо дандаа л айж эмээсэн бүх хүний дуу татарчихсан маягтай тиймэрхүү л болчихсон. Тэгэхэд чинь би уг нь яагаад ч тэгсэн юм бэ дээ, тэр хүрэнээс явмаар л санагдсан юм байлгүй дээ. Наашаа Төгрөг рүү оргож ирсэн юм даа, үнэн хэрэг дээрээ. / инээв / Тэгээд Төгрөгт ирээд манай нэг хүргэн ах байсан юм байна лээ. Тэгээд тэрнийгээ ч яаж олсон юм, нэг ганц сар болж байтал нэг багш ирж танхимд орохгүй юу чамайг аваачна гэхээр би морьных нь эмээлийнх нь араар сууж тэгээд л Төгрөгийн бага сургуульд анх орсон маань тэр л дээ, оргодол. Тэгээд тэр хүрээний лам нар яаж баригдаж барьсныг нь би мэддэггүй л дээ. Улсууд ч бараг хоорондоо ярьдаггүй, явчихсан л гэдэг. Шивэр авир яриа хөөрөөтэй, ер нь ардууд бол одоо бодоход сэтгэл санаагаар маш их унасан байдалтай л байсан юм. Уг нь тэр Зэргийн хүрээ чинь Төгрөг, Зэрэг хоёр дотроо олон сүмтэй гэдэг юм уу, олон дугантай. Тэр дуган бүр нь өөр өөр үүрэгтэй юм байна лээ ш дээ, тэр дотор нь би жүдийн дацан, дацан гэж нэрлэдэг ш дээ , тэр шашны хэлээр бол. Тур юуны тийм юмны дацан, ийм юмны дацан гээд дацангууд л байсан. Миний мэдэхээр миний их сүрхий дуулж байсан юм бол тэр жүдийн дацан гэж лав байсан. Тэр өөр өөр үүрэгтэй, өөр өөр ном үздэг бололтой Төгрөг чинь гурав дөрвөн дацантай, Зэргийн хүрээ 6 дацантай байсан гэсэн байх аа. Сүүлд нэг 460-аад лам байсан байх, Зэргийн хүрээнд. Хамгийн олон ламтай нь, Төгрөгийн хүрээ нь 200 гаруй ламтай байв уу даа. Харин тэр нөгөө банди байсан ном зом нь таардаггүй байсан юм болов уу, гүйцэд болоогүй байсан юм болов уу, тэр хурал номонд бид хоёр Тогмид бид хоёр ордоггүй. Тийм олон банди нар бэлтгэгдэж байсан юм байлгүй дээ, бодоход.

Билэг-Өрнөх: Сүм хийдийг тараасны дараа ном судар бурхан шүтээнийг нь яасан бол?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дамдин: Өө тэр дандаа ачдагийг нь ачиж, уг нь тэр цамын хэрэглэлийг нь тэр Манханд чинь Самбуу ноён гэж их нэртэй ноён байсан. Бараг хорь гаруй жил сум ахлав уу, бараг ардуудад их нэр хүндтэй. Сүүлд яаж байхад их нэр хүндтэй лам байсан юм гэнэ лээ. Тэр манай нэг хүргэн ах хэлж байдаг юм аа. Тэр ноёны одоо галч нь гэдэг юм уу, тийм юм байсан гэж. Тэр ноёны тухай ярьж байлуу. Тэгээд тэр ноёныг бариагүй юм гэсэн. Хөрөнгийг нь хураана, манай тэр хүргэн ах л их тодорхой ярьж байсан юм. Ноён өөрөө зүүн ууланд амарч байсан, тэгээд дуудаж ирүүл гээд гурван хүн гэрт нь сууж байсан. Тэр тийм л юм ярьдаг юм. Их сүртэй ноён байсан, ер нь нутгийнхан бол тэр ноёныг их шүтдэг. Бараг нэрийг нь ч хэлдэггүй. Тэр ноёны холбогдолтой юм бас их байдаг юм аа. Тэр чинь их ...

Билэг-Өрнөх: Энэ хүрээний жасын тухай та юу сонсож байсан бэ?

Дадмин: Баахан хөрөнгөтэй, хөрөнгө л байсан гэсэн. Гол нь мал голдуу байсан юм байх аа. Одоогийнхоор хэлвэл одоо бараа таваар гэдэг юм уу цай ч гэдэг юм уу, даалимба ч гэдэг юм уу. Тэр чинь бас үе үе хурал дээр бас гардаг л байсан юм. Одоо лав мал, жасын мал гэж тэмээ их олон байлаа. Манай аавынх ч гэсэн жасын тэмээ гэж хариулж байлаа. Одоогийнхоор бодоход чинь нэг том лам гэдэг юм уу даа, тэр хүн тэр малыг чинь гардаж хариуцдаг байсан юм уу даа. Тэр дотроо тийм тусдаа мал гэж байсан юм уу. Жасын мал гэж тэмээ байгааг л би сайн мэдэж байна. Манай аав тэгэхэд чинь, манай аав ээж их олон хүүхдүүдтэй тэгээд тэр жасын тэмээ хариулж нэг хэсэг амьдарлаа л даа. Бас хүрээнд нэлээн ээлтэй гэх үү, манай аав сүүлд л сургуульд орсон хойноо харахад тэр төвд ном энэ тэрийг чинь уншдаг. Түүгээр хөгшчүүл их цугладаг. Тэрийг чинь уншиж хуулж тараадаг юм уу одоо сүм хийдийн захиалгаар бичдэг юм уу, тэр бийр янтай нийлээд одоо тэр ном энэ тэрийг чинь янзын гоё бичдэг байсныг бодоход одоо тэр хэлийг бол мэддэг л байсан юм байлгүй.

Билэг-Өрнөх: Энэ хийдийг хаах, нураах тушаал ямар хүмүүс өгч байсан юм бол?

Дамдин: Дотоод яамны л энэ одоогийнхоор бол ногоон малгайтнууд л гэж дотоод яамны улсууд л голцуу, тэр лам нарыг ачихад ч гэсэн дандаа яам нарын л улсууд голцуу машинтай ирж ачаад л тэгээд одоо бараг ингээд ингээд тэр явлаа, энэ явлаа. Одоо миний ээлж гээд хүрээнд байсан улсууд чинь өдөр шөнөгүй л юуг дэнсэлж байна гэдэг юм уу тийм байсан гээд нутгийн улсууд ярьдаг юм, тэр үед. Тэгэхэд чинь би сургуульд орчихсон байсан. Тэр чинь гучин долоо он биз дээ, гучин найман он хоёр л. Гучин долоон онд л манай энэ Төгрөгийн хүрээ, Зэргийн хүрээний лам нарыг бараг яасан байх. Тэгээд сонин юм дуулддаг л юм. Ухаан нь Зэргийн хүрээнд чинь тэр эм барьдаг хэд хэдэн хүн байсан. Тэд нар цөм л баригдаад явцгаасан. Тэр Төгрөгийн хүрээнд нэг Чойжин гээд хүн байсан. Ингээд нутгийнхан нь их харамсаж ярьдаг юм байна лээ. Нэг хэсгийг нь одоо аваад явчихсан, одоо миний ээлж гээд Чойжин гэж одоо ид шидтэй гэдэг юм уу, мэргэ төлөгтэй холбоотой л тийм хүн байсан. Одоо миний ээлж боллоо. Намайг барихаар гурван хүн аймгаас гарсан байна аа гэж хэлээд л өөрөө явчихсан гэж ярьдаг юм. Энэ нутгийнхан л тэгж хэлдэг юм байна лээ. Цаашаа хараад л одоо намайг барихаар наашаа гарч байгаа юм байна гээд. Орон дээрээ цаашаа харж хэвтээд л явчихсан гэдэг юм. Тэгээд тэр улсууд ирэхэд, тэр ирэх нь ирсэн. Тэгээд л ийм юм болсон гээд л тэгээд л өөр тийшээ л явсан юм байлгүй. Тийм юм хэлдэг юм. Тиймэрхүү сонин юм тэр үед ч бас гарч л байсан л даа. Хорлоо багш ч тэрнийг дуулж мэдэж байсан

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байх аа. Уг нь би чинь одоо 5 эгчтэй, цөмөөрөө л лам байсан улсууд, хар болсон тийм л улсууд хүргэн ахтай болсон. 400, 600, 700-аад лам байсан, тэр хоёр хүрээнд гэж бодоход чинь тэгээд ер нь бололцоотой гэсэн эрэгтэйчүүд нь хүрээнд сууж байсан байж таарахаар шахуу юм бодогдож байгаа юм л даа, одоогийнхоор болвол. Тэгээд сүүлд нь баригдаагүй хэсэг нь хар болоод авгай хүүхэд аваад, өөрөө зүсээ хувиргасан. Тэр манай хүргэн ах болдог 2, 3 хүн байгаа. Тэд цөм ном мэддэг. Тэгээд дандаа энэ одоо тэр нөгөө хүрээ лам нараас бусад нь сүүлд нь дахиад дэлгэрнэ гэдгийг л одоо хэлдэг улсуудыг тийм их нэлээн олон хүн байсан юм шүү, ер нь. Жаахан сүүхээтэй гэдэг юм уу, тийм хүмүүс нь урьдчилаад хар болчихсон. Цүлтэм ч гэдэг хэн билээ, тэр тийм улсууд бүр гадагшаа ийш тийшээ хүртэл явчихсан тийм нутгийнхан ярьдаг юм. Тэр хар болсон улсууд энд байхгүй энэ тэр гээд.

Билэг-Өрнөх: Энэ Зэргийн хүрээ төвдийн хүрээтэй холбоотой байсан болов уу? Төвд орны?

Дамдин: Аа тэр Самбуу ноён л голцуу нааш, цааш явдаг байсан гэсэн. Тэр нутгийн ноён. Хаанаас нь юм, тэр Төвд рүү яваад юу авчирсан. Тэр цамын хэрэглэлийг авчруулсан, ганжуур, данжуурын 300 гаруй боть, ялангуяа тэр Зэргийн хүрээнд дээр ганжуур, данжуурын бүрэн боть байсан гэж хэлдэг юм даа, нутгийнхан. Гурван зуу гаруй боть ном байсан, тэгээд заримыг нь шатаагаад. Ер нь тэр номыг нь чухал чухал, одоогоор бол бодвол чухал судрууд байсан. Нэг хэсгийг нь шатаагаад. Тэр цамын хурал номын зарим хэрэглэлийг устгаад тэгсэн л юм билээ. Одоо энэ Өөршийн бор үзүүр гээд байгаа даа. Тэнд ч гэсэн тэр сүмийн Лхамын хэрэглэлүүдийг, бас тэр дотор тэр тахил номын юмнууд орсон л байдаг байлгүй, шатаасан. Ором энэ тэр нь саяхан болтол байдаг л байсан. Дугуй, дугуй дандаа л чулуу мулуу нь түлэгдчихсэн, газар нь түлэгдчихсэн. Тэнд шатаасан. Тэнд хурмаштын элс гэж байдаг юм. Тэр чинь тэнд аваачиж бас энэ цам хурал номын хэрэглэлүүдийг бүлсэн байдаг юм байна лээ. Би нэг явж байгаад тэр элсэн дундуур гараад ирсэн чинь зөндөө тийм тахилын цөгц энэ хэнгэрэг гээд байдаг юм ш дээ. Одоо юу гэж хэлдэг билээ, тэр бөмбөр билүү. Хэнгэрэг тэрний тэр араам нь, үндсэн араам нь тэр дотроос нөгөө цан гээд байдаг даа. Их дуутай, тийм гууль цасаар хийсэн юу байдаг ш дээ. Одоо энэ юу нь хүртэл байгаа ш дээ, хөгжимд. Аа тийм юм хүртэл элсний юунаас гарсан хөглөрөөд л байж байгаатай би таарч тэгээд тэр байтугай ийм явдал хүртэл болж байсан юм. Тэрнийг аваачиж энэ сургууль, клуб, уран сайхныхан чинь тэр цан, тэр цан ч одоо олдохгүй. Тэрнийг тэдэнд өгвөл яасан юм гэсэн би хүргэн ах, эгчдээ нартаа зэмлүүлээд тийм юм байж таарахгүй. Чи оролдоогүй биз, тэр чинь тэгээд зүгээр байж байгаа биш шахуу юм ярьж тэр нутгийн мар хүн ч билээ. Тэрнээс нэг цөгц авсан юм уу, тэрнээс болж олон ботго үхсэн. Хар өлөн гээд байдаг юм даа, одоо тэнд. Хар өлөнгөөр одоо хаваржингаа ингэ тэмээ буйлсан энэ тэр гээд намайг загнаад. За чи оролдоогүй биз, би чинь одоо бүр... Тийм ээ, би чинь бараг багш болчихсон, амралтаараа л тэгж таарсан юм байх аа. Энэ арван жилд би нэг багш байсан юм л даа, юугаа төгсөөд. Тэгж байхад асуусан чинь харин намайг хүртэл тэгж зэмлэж байсан удаатай. Тэгэхлээр тэр сүм хийдийн тэр зарим хэрэглэлийг тэр энэ тэнд л булж далдалж болох нэгийг нь шатааж тэгж л байсан юм байна лээ л дээ.

Билэг-Өрнөх: За их баярлалаа.

Дамдин: Зүгээр, иймэрхүү л юм байх шив дээ.